

ДОРНОД АЙМАГ
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/68

Чойбалсан

Г

Г

“Эрүүл мэндийн ажилтны нийгмийн
хамгааллыг дэмжих” сарын аян зарлах тухай

Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/295 тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 1а/3543 дугаар албан бичиг, удирдлагын зөвлөлийн 8 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сарын аяныг 2022 оны 8 дугаар сард зохион байгуулсугай.


2. Аяны хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Ж.Энхчимэг болон Хүний нөөцийн албаны дарга Б.Байгальмаа, Эмнэлгийн тусламж үйчилгээний чанар, аюулгүй албаны дарга Б.Болорцэцэг, Сургалт, судалгаа хамтын ажиллагааны албаны дарга Х.Ууганцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төсвийн хүрээнд зохицуулан шийдвэрлэхийг Эдийн засаг, санхүүгийн албаны дарга Ө.Сийлэгмаад зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын ажилтан Д.Урантунгалагт даалгасугай.




 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын
 2022 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн
 08 дугаар тушаалын хавсралт

“ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ САР”-ЫН
 АЯНЫ ХҮРЭЭНД 2022 ОНЫ 8 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН
 ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.08.01

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хэрэгжүүлэх	Хүрэх үр дүн	Шаардагдах төсөв
1	Эмч нарыг ажлын хос хувцсаар хангах	8 дугаар сарын 4 дэх 7 хоногт	ХНА, ЭЗСА	Ажлын хувцсаар хангагдаж байгаа эмч нарын сэтгэл ханамж дээшилсэн байна.	8 сая төгрөг
2	Сувилагч, тусгай мэргэжилтнүүд өмсөх гадуур хүрмээр хангах	Хавар, намрын улиралд 8-р сарын эхний хагаст	ХНА, ЭЗСА	Ажлын хувцсаар хангагдаж ажилтнуудын сэтгэл ханамж дээшилсэн байна.	11,9 сая төгрөг
3	Галын аюулд гэр нь өртсөн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн туслах сувилагч Н.Сайндүүд иж бүрэн гэр авч өгөх	Сардаа	Удирдлагын зөвлөл	Амьдрах орон байртай болж ажиллах урамтай болно.	6 сая төгрөг
4	Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн туслах сувилагч Н.Сайндүүд тасаг хамт олноос хандивын аян өрнүүлэх	Сардаа	ХНА	Хэрэгцээт зүйлсээ авч гэр орон ньтохижсон байна	
5	Ажилтнуудын хоол, унааны нэмэгдлийг 6000 төгрөг болгон 2 дахин нэмэгдүүлэх	Сардаа	Удирдлагын зөвлөл	Чанартай хоолоор хангагдаж ажлын бүтээмж сайжирна.	156 сая төгрөг /8 сараас эхлэн 5 сар олгоно/
6	Тасгуудын сувилагч нарын постонд сувилагч нарыг амрах креслоор хангах	Сардаа	Удирдлагын зөвлөл	Сувилагч нарын ажиллах орчин нөхцөл сайжирна.	4.6 сая төгрөг
7	Гүйцэтгэлийн санхүүжилтийн хүрээнд бүх ажилтнуудад	8 дугаар сардаа	Удирдлагын зөвлөл	Ажилтнуудын сэтгэл ханамж сайжирна. Ажлын	250 сая төгрөг

	цалингийн 100-50 хувийн урамшуулал олгох			гүйцэтгэл бүтээмж дээшлүүлэх	
8	Хавдаргүй ирээдүй өнөөдрөөс уриатай холын зайны гүйлт хийж байгаа Хавдрын тасгийн сувилагч Б.Алтантуяаг 1 сарын цалингаар урамшуулах	Сардаа	Удирдлагын зөвлөл	Нийгмийн хамгаалалд дэмжлэг болно.	850686 төгрөг
9	Өөрийн санаачилгаар хариуцсан машиныг өнгө үзэмж, тохь тухыг хангасан жолооч М.Батсүхийг 1 сарын цалингаар урамшуулах	Сардаа	Удирдлагын зөвлөл	Ажиллах мотиваци Нэмэгдэнэ.	743029 төгрөг
10	Би сувилагч төсөлт уралдааны 2 дугаар шатанд шалгарсан 8 сувилагчид 1 сарын цалингийн урамшуулал олгох	8 дугаар сарын 2 дугаар хагаст	Удирдлагын зөвлөл	Ажиллах мотиваци нэмэгдэнэ.	6.4 сая төгрөг
11	Нийт эмэгтэй ажилтнуудын дунд урьдчилан сэргийлэх зорилгоор хөхний үзлэг зохион байгуулах	Сардаа	ЭТА, ХНА, ССХАА	Өвчлөлөөс урьдчилан сэргийлнэ.	2 сая төгрөг
12	Ажилтнуудад хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах сургалт хийх	Аяны хугацаанд	Хавдрын тасаг	ССХАА	
13	Хавдрын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор хавдрын тасгийг өргөтгөн 10 ортой болгон, дотрын тасгийн 1-р давхарт шилжүүлэн байршуулах	Сардаа	Удирдлагын зөвлөл, Албад, хавдрын тасаг	Үйлчлүүлэгч болон ажилтнуудын ажиллах орчин нөхцөл сайжирч сэтгэл ханамж нэмэгдэнэ.	
	Хавдрын тасгийн			Үйлчлүүлэгч	

14	өрөөнүүдэд урсгал засвар хийх	Сардаа	ЭЗСА	болон ажилтнуудын ажиллах орчин нөхцөл сайжирч сэтгэл ханамж нэмэгдэнэ	2.5 сая төгрөг
15	Хавдрын тасагт шаардлагатай хэрэгсэл, ор, зөөлөн эдлэлээр хангах	Сардаа	ЭЗСА	Үйлчлүүлэгч болон ажилтнуудын ажиллах орчин нөхцөл сайжирч сэтгэл ханамж нэмэгдэнэ	2 сая төгрөг
16	Химийн өдрийн эмчилгээний өрөөг тохижуулах, заавар, зөвлөмжүүдийг байршуулах	Аяны хугацаанд	Хавдрын тасаг	Үйлчлүүлэгчийн орчин нөхцөл сайжирч сэтгэл ханамж нэмэгдэнэ.	
17	Хүүхдийн хэсгийн гал тогоог засварлан сайжруулах	Сардаа	ЭЗСА	Ажилтнуудын ажиллах нөхцөл, хоолны амт чанар сайжирна.	5 сая төгрөг
18	Хүүхдийн хэсгийн гал тогоонд агааржуулалт хийх	Сардаа	ЭЗСА	Ажилтнуудын ажиллах нөхцөл, хоолны амт чанар сайжирна	5.5 сая төгрөг